



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### XIII. ХЭЛЭЛЦСЭН нь:

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагааны тухай:

### ТЭМДЭГЛЭСЭН нь:

Засгийн газрын 2009 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай” 243 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлалтай Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын (хуучин нэрээр) харьяанд ажиллаж байсан Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, захирлыг томилон, дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж, үйл ажиллагааг нь зохих журмын дагуу эхлүүлэх арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон Төрийн өмчийн хороонд даалгасан.

Төрийн өмчийн хорооны 2009 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 347 дугаар тогтоолоор “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ыг өөрчлөн байгуулж, дүрэм, бүтэц зохион баталж байсан. Түүнийг шинэчлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын дүрэм, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын дүрмийн 1.2-т “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь тэмөр замаар тээвэрлэн нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг Монголын вагонцистерн болон автоцистернд шилжүүлэн ачих, хадгалах үндсэн чиг үүрэг бүхий төрийн өмчит үйлдвэрийн газар мөн” гэж заасан бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх үндсэн чиг үүрэггүй байхаар баталсан. Мөн дүрмийн 4.8 дахь хэсэгт газрын тосны бүтээгдэхүүн импортлох, худалдах, үйлчилгээ үзүүлэх асуудлыг тодорхой тусгаагүй явж ирсэн байна.

Тус байгууламж газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, түүний дотор шатахуун, тос тосолгооны материалын импорт, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүйн улмаас орлого олох боломж хязгаарлагдмал, зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалж орлогын төлөвлөгөө тасрах эрсдэлтэй байна.

Өмнө нь “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 3 жилийн хугацаатай авч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусчээ.

000063

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 509 дүгээр тогтоолын 2.3-т ...“Байгууллагын дүрмийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн болон бөөний худалдаа эрхлэх, импортлох, үйлчилгээ үзүүлэх талаар нэмэлт өөрчлөлт оруулах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх”... гэж заасны дагуу газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, үйлчилгээ үзүүлэх асуудлыг “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын дүрэмд тусган холбогдох зөвшөөрлийг авч ажиллах талаар үүрэг даалгавар өгсөн боловч хэрэгжээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2-т Төрийн өмит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын үр ашгийг дээшлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга нарт үүрэг болгосны дагуу дээрх асуудлыг судалж шийдвэрлэх шаардлагатай гэж үзлээ.

#### ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын дүрэмд тодорхой тусгагдаагүй газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх зөвшөөрөл авах асуудлыг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын захирал Г.Гансух нарт үүрэг болгов”... гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

